МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn
Утас 7044 5018, Факс 7044 3206

2022.01.31 № 1а/82

танай ______________-ны №______________-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР
Г.АЗЖАРГАЛ ТАНАА

Аймгийн хэмжээнд зохион байгуулсан авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөөний биелэлтийг khutulbur.iaac.mn-д байршуулан хувийг хүргүүлэв.

Хавсралт 12 хуудастай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

605210216

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
# /2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС/

2022 оны 01 дүгээр сарын 31 Номгон

| Д/д | Үйл ажиллагаа | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хоёр дахь үе шат ( 2020 - 2023) хүрэх түвшин , үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | 4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | 2017 - 2022 | - | 1.Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлтийн мэдээллийн санг хөгжүүлсэн байх<br>2.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн системийг хөгжүүлсэн байх | Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн 2 дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 23 этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг аймгийн www.bayanhongor.gov.mn, цахим хуудсанд байршуулан ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. | 100% |
| 2 | | 5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр | 2017 - 2022 | - | Хүний нөөцийн системтэй уялдсан "Төрийн албаны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийн сан"-г хөгжүүлсэн байх | Төрийн албаны тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч, иргэдэд сурталчлах зорилгоор тус салбар зөвлөлөөс 40 гаруй видео, нэвтрүүлэг, постер зэргийг бэлтгэн төрийн албаны зөвлөлийн баянхонгор аймаг дахь салбар зөвлөл цахим групп, аймгийн www.bayankhongor.gov.mn албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | | | | нийтэд сурталчлан ажиллалаа. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам"-д заасан нөөцийн бүртгэлийг аймгийн www.bayankhongor.gov.mn албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж хэвшсэн байна. | |
| 3 | 4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | 1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2022 | - | 1. Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байх 2. Шалгуурт нийцсэн ТЖАХ-ийн эзлэх хувь - 70%-аас дээш | Төрийн албаны ерөнхий нөөц бүрдүүлэх шалгалтыг 2 удаа зохион байгуулж, 108 иргэний ерөнхий нөөцийг бүрдүүллээ. Мөн төрийн төрийн захиргааны байгууллагын туслах түшмэлийн 86 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 12 сарын 20-ны өдөр зохион байгуулан, 23 сул орон тоог нөхөж салбар зөвлөлийн 2021 оны 15 дугаар тогтоолоор нэрийг дэвшүүлсэн. Төрийн албанд ажиллаж байгаа зөрчилтэй томилгоотой 210 хүний судалгааг гаргаж зөрчлийг арилгахаар ажиллаж байна. | 100% |
| 4 | 4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл | 1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох | 2017 - 2022 | 6800000 | Албан бичиг цахим орчинд баталгаажиж, мэдээлэл солилцох мэдээллийн систем бий болсон байх | Аймгийн хэмжээнд "ERP" систем ашиглаж байгаа нийт 3000 гаруй ажилтан албан хаагч байгаагаас үндсэн ажилтан буюу систем идэвхтэй ашиглаж байгаа 2927 алба хаагч бүртгэлтэй дотоод үйл ажиллагаандаа ашиглаж албан мэдээллийг солилцон | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллалаа. | |
| 5 | солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | 2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах | 2018 - 2022 | - | Байгууллагуудын мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн байх | Аймгийн цахим хуудас /bayanhongor.gov.mn/-д аймгийн хэмжээнд хэрэгжиж, мөрдөгдөж байгаа захирамж, тушаал, тогтоол шийдвэрүүдийг тухай бүр бүртгэж 500 гаруй төрлийн олон нийтийн шинжтэй мэдээлэл хуваалцсан. | 100% |
| 6 | 4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд: | 2018 - 2022 | 3000000 | Хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувь буюу 36387 албан хаагчийг давтан сургасан байх | Төрийн байгууллагуудын нийт 2560 албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан, хуулийн үйлчлэлд хамаарах 366 албан тушаалтанд давхардсан тоогоор 6 удаа, ЭБАТ-уудад 2 удаа тус тус сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн хэмжээнд 50 сэдвийн хүрээнд төлөвлөгөөт 37, төлөвлөгөөт бус 3, захиалгат 20, нийт 70 удаагийн сургалтаар 4000 гаруй төрийн албан хаагч, иргэдэд цахим болон танхимын хэлбэрээр сургалт зохион байгуулж 500 гаруй иргэд, төрийн албан хаагчдад хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутгийн телевиз, аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар сурталчлан, хялбаршуулсан гарын авлага бэлтгэж иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллалаа. Тус нөлөөллийн ажлуудын үр дүнд хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн. | 100% |
| 2. Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 7 | 4.1.2.1. Төрийн | 2. Төрийн | 2018 - 2022 | - | Сүлжээний хэвийн | МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж буй Төрийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | | | ажиллагааг хангасан байх | цахим үйлчилгээний E-Mongolia цахим платформоор дамжуулан 19 сум, аймгийн ЗДТГ-ын Үйлчилгээний нэгдсэн төвийн операторууд иргэдэд цахим үйлчилгээг үзүүлж байна. Мөн 2 дамжлагат үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Тус онд 4000 гаруй иргэдэд цахимаар үйлчилгээ үзүүлж сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажилласан. | |
| 8 | 4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2018 - 2022 | - | Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг ТББ-д шилжүүлсэн байх | Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны а/272 дугаар тушаалаар “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоож цэгийн тоог одоогийн тоо хэмжээнээс бууруулах тухай чиглэл ирснийг хэрэгжүүлэх зорилгоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2021 онд шинээр олгоогүй. Тайлант хугацаанд 110 иргэний хүсэлт ирүүлснээс тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах баримт бичгийн шаардлага хангасан 106 иргэний тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, шинээр авах хүсэлттэй 4 иргэний материалыг буцааж, 1 иргэний тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрийг сольж олгосон. Холбогдох журам 100 хувь хэрэгжсэн байна. Боловсролын салбарт төрийн өмчийн 29 сургууль, 37 цэцэрлэг төрийн бус өмчийн 2 сургууль, 6 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас тус онд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгуулах | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 хүсэлт ирүүлснийг шийдвэрлэн ажилласан. Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн хувьд тус онд эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх 21, сувилал 1, арьс харшил, бэлгийн замаар дамжих халдварын эмчилгээ, оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулах 1, нийт 23 байгууллагад тусгай зөвшөөрөл шинээр олгосон. Эмийн сангийн хаягийн өөрчлөлтийг 2 байгууллагад, сунгалтыг 2 байгууллагад тус тус хийсэн байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч боловсрол болон эрүүл мэндийн салбарын 5 байгууллагын дотоод үйл ажиллагаанд "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран хяналт шалгалт хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан. | |
| 9 | 4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх | 3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх | 2018 - 2022 | - | Хяналт шалгалтын тоог цөөрүүлсэн байх | Байгууллага бүр хяналт шалгалтын нэгжийг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж, дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа. Аймгийн засаг даргын тамгын газар болон Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг сумдын Засаг даргын Тамгын газрын захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр, аймгийн дахь төрийн албаны салбар зөвлөлөөс төрийн албаны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр, Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох | | | | | тусгай удирдамжаар тус тус дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж дүгнэлт зөвлөмж хүргүүлэн ажилласан. Мөн аймгийн хэмжээний бүх сум, байгууллагуудад тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр зөвлөмж өгч ажиллалаа. | |
| 10 | 4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | 2017 - 2022 | - | Үнэлгээ хийлгэх ажил хэвшсэн байх | Төрийн байгууллагын үйлчилгээний чанар хүртээмж, цахим хуудасны ил тод байдлыг сайжруулах зорилгоор нэр бүхий 8 байгууллагын үйл ажиллагаанд “Хөгжилд залуучуудын оролцоо түншлэл” ТББ-ын шалгаруулан 1.0 сая/төг-өөр судалгаа хийлгэсний үр дүнд аймгийн цахим хуудасны ил тод байдал өмнөх оноос 12 хувиар сайжирсан үзүүлэлттэй байгаа бөгөөд тус онд авлигын гэмт хэрэг 4 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. | 100% |
| 11 | | 2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх | 2018 - 2019 | - | | Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх зорилгоор ажилтныг үнэлэх үнэлгээний 1 төхөөрөмж, санал хүсэлт хүлээн авах хайрцгийг тус тус байршуулсан. Иргэдээс өгсөн үнэлгээгээр тус төвд үйлчилгээ үзүүлж буй төрийн албан хаагчдын 53 хувь нь харилцаа, хандлага сайтай, 47 хувь нь харилцаа хандлагаа сайжруулах шаардлагатай судалгааны дүн гарсан. | 100% |
| 3. Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 12 | 4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, | 1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын | 2017 - 2019 | 913938 | | Замын сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд 913.938 мянган төгрөгийн 15 төсөл арга хэмжээг санхүүжүүлж сангийн мэдээллийг шилэн дансанд | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах | | | | нээлттэй байршуулсан. | 100% |
| 13 | зарцуулалтыг ил тод, хяналттай болгох | 2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх | 2017 - 2020 | - | Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг олон нийтэд ил тод мэдээлдэг болсон байх | Улсын төсөв болон Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр шилэн дансны цахим хуудсанд оруулж иргэд, олон нийтэд мэдээлсэн. Мөн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих" журам шинээр батлагдсан. Журмын дагуу тус аймагт 2021 онд төсөв батлагдаагүй болно. | 100% |
| 14 | 4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | 1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах | 2017 - 2022 | - | Төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгаж хэвшсэн байх | Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн тухай үйл ажиллагааны журам, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам болон бусад холбогдох хууль журамд нийцүүлэн аймгийн төвийн болон сумдын иргэдийн санал тулгуурлан төлөвлөн, эрэмбэлж хуулийн хугацаанд | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батлуулан хэрэгжүүлсэн. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх арга хэмжээг сумдын иргэдийн санал болон Баянхонгор аймгийн иргэний танхим буюу нэг цэгийн үйлчилгээгээр иргэдээс санал авч ажлын хэсгээр эрэмбэлэн 64 арга хэмжээг батлуулан хэрэгжүүлсэн. | |
| 15 | | Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх | 2018 - 2022 | - | Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангасан байх | Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан. | 100% |
| 16 | 4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | 2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2019 | - | | Тус аймагт томилох эрх бүхий албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой Санхүүгийн хяналт аудитын албанаас 201 сая төгрөгийн хохирлыг барагдуулах тухай 25 албан шаардлага, 12 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавин хамтран ажиллаж байна. | 100% |
| 6. Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх | | | | | | | |
| 17 | 4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг | 4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр | 2018 - 2020 | 3000000 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажил хэвшсэн байх | “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын 2021 оны а/24 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | 2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх | 2018 - 2022 | - | Жагсаалтад дурдсан төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн байх | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сэргээн засах эмчилгээ болон боловсролын үйлчилгээг 2021 онд 35 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлж ажилласан. Мөн Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв 70 сая төгрөгийн төсөвтэйгөөр нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэн ажилласан. Төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг шилэн дансанд сар бүр байршуулан олон нийтэд ил тод нээлттэй байдлыг бүрдүүлэн ажиллалаа. | 100% |
| 10. Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх | | | | | | | |
| 20 | 4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах | 2017 - 2022 | - | Төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх | Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хүргүүлэн биелэлтийг хагас бүтэн жилээр хүлээн авч соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Аймгийн төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ 68.8 хувь үнэлэгдсэн. Энэ нь 2019 оны 71.3 хувьтай үзүүлэлтээс 2.5 хувиар буурсан нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор иргэдийн үйлчилгээ авах хүсэл сонирхол их байсан ч эрх нь нийтийн эрх ашгийн төлөө тодорхой хэмжээгээр хязгаарлагдсантай холбоотой байна. Харин аймгийн хэмжээнд 3 удаагийн аяныг зохион байгуулсны үр дүнд авлигын гэмт хэрэг өмнөх оноос 4 нэгжээр буурч, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн цахим хуудасны ил тод байдал өмнөх оноос 12 хувиар сайжирсан үзүүлэлттэй байна. | |
| 21 | 4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх | 2017 - 2022 | 2000000 | Сургагч багш нарыг үе шаттайгаар сургаж, сургагч багшийн тоог нэмэгдүүлсэн байх | Авлигатай тэмцэх газраас "Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх", "Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж соён гэгээрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах зорилготой сургалтад Хууль, эрх зүйн хэлтсийн 1 мэргэжилтнийг хамруулж сургагч багшаар бэлтгэн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хяналт тавьж ажиллалаа. Сургагч багшийн зүгээс<br>1. "Шударга удирдагч" аяныг төрийн байгууллагуудын дунд зарлан зохион байгуулсан энэ хүрээнд:<br>-АТГ-аас ирүүлсэн 14 төрлийн ТВ шторк болон аймгийн хэмжээнд байгууллагуудад бүтээсэн авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 10 төрлийн ТВ шторкийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж лед дэлгэцээр 63 удаа цацаж ажилласан.<br>-Хөдөлгөөнт зураг 10 удаа, зурагт хуудсыг 223 удаа, цахим номыг аймгийн bayankongor.gov.mn цахим хуудсанд байршуулан ажилласан. Орон нутгийн ТВ-ээр өдөр бүр сурталчлан ажиллаж байна.<br>2.Авилаггүй нийгмийн төлөө-5 аяны хүрээнд нэг сарын хугацаанд өдрийн 3 удаагийн давтамжтай 110 удаа цацаж ажилласан.<br>-Хөдөлгөөнт зураг 15 удаа, зурагт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуудсыг 275 удаа, цахим номыг аймгийн bayankongor.gov.mn цахим хуудсанд байршуулан ажилласан.<br>-Дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 2,194,500 төгрөгийн гэрээ байгуулан 1 сарын хугацаанд авлигын эсрэг зөвлөгөөг MGL радиогоор 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фэйсбүүк хуудсаар 40 удаагийн давтамжтай давхардсан тоогоор нийт 80680 иргэнд хүргэж ажилласан. | |

ХЯНАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.САРАНГАРАВ

9007342 0320100002

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ж.ЛХАМДУЛАМ